



60

**БНМАУ**  
**УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН**  
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1991 оны 10 сарын 27

№ 308

Улаанбаатар  
хот

**Компани байгуулах тухай**

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас **ТОГТООХ** нь:

1. Худалдаа, үйлдвэрлэлийн "Туулимпэкс" нүүсийг Улаанбаатар хотын эдийн засгийн гадаад харилцаа, худалдаа, үйлчилгээ, бараа солилцооны ажлыг хариуцан гүйцэтгэх Худалдаа, үйлдвэрлэлийн "Туулимпэкс" /УУТ/ компани болгон өөрчлөн байгуулсугай.

2. "Туулимпэкс" /УУТ/ компанийн дүрмийг хавсралтын дагуу баталсугай.

3. Хотын захиргааны харьяа болон бусад байгууллагуудын захиалгыг биелүүлж, тэдэнтэй хамтран ажиллахыг "Туулимпэкс" /УУТ/ компани /н.Санчин/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны 1990 оны 285 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААНЫ ДАРГА

Д.ЭНЭЖИН

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хурлын  
гүйцэтгэх захиргааны 1991 оны  
308 дугаар тогтоолоор батлав.

ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН "ТУУЛИМПЭКС"  
УУГ/КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Худалдаа, үйлдвэрлэлийн "Туулимпэкс" УУГ компани /цаашид "компани" гэж нэрлэх /нь Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, түүний харьяа байгууллагуудын эдийн засаг, техникийн гадаад харилцаа, худалдаа, үйлчилгээ бараа солилцооны ажлыг хариуцан гүйцэтгэх, тэдэнд зуучлах зорилгоор гадаад худалдааны үйл ажиллагааг аж ахуйн бүрэн тооцооны үндсэн дээр бие даан явуулахаар Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дэргэд байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээх БНМАУ-ын хуулийн этгээд мөн.

2. Компани нь өөрийн үйл ажиллагааг БНМАУ-ын аж ахуйн нэгжийн хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн дагуу явуулна.

3. Компани нь аж ахуй, санхүү, нийгэм эдийн засгийн үйл ажиллагааныхаа үр дүнг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны өмнө шууд харууцан тайлагнана.

4. Компани нь улс, хот болон тэдгээрийн байгууллагуудын хүлээсэн үүргийг хариуцахгүй, компанийн хүлээсэн үүргийг улс, хот болон тэдгээрийн байгууллагууд хариуцахгүй.

5. Компани нь мэдэлдээ байгаа эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ БНМАУ-ын хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу хэрэгжүүлнэ.

6. Компани өөрийн нэр бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

7. Компани Улаанбаатар хотод байрлана.

Хаяг: ЗИОБ II. Улаанбаатар II. Сүхбаатарын талбай. Худалдаа, үйлдвэрлэлийн "Туулимпэкс" компани.

ХОЁР. Компанийн үйл ажиллагааны чиглэл

8. Компани нь энэхүү дүрмийн I дүгээр бүлгийн I дүгээр зүйлд заасан зорилгыг хэрэгжүүлэхийн тулд өөрийн үйл ажиллагаандаа дараах чиглэлийг баримтлан ажиллана. Үүнд:

а/ Улаанбаатар хотод шинээр байгуулагдах үйлдвэр, үйлчилгээний газруудын тоног төхөөрөмж, материалыг гэрээлж нийлүүлэх.

б/ Улаанбаатар хотын байгууллагуудад үйлдвэр техникийн зориулалттай бараа материал олох, шинэ техник, жижиг технологи худалдан авахад нь зуучлах, " " худалдан авах.

в/ Хотын хүн амын өргөн хэрэглээний болон соёлын ховор барааны хэрэгцээт захиалгыг үндэслэн тодорхой хэмжээний экспорт-импортын үйл ажиллагааг явуулах, шаардлагатай үед газар дээр нь тохиролцооны үнээр худалдан авч, гадаад худалдааны нөхцөл журмаар нийлүүлэх.

г/ Хамтын үйлдвэр, үйлчилгээний газар, байгууллага байгуулж, дотоодын хэрэгцээг хангах, экспортын барааны эх үүсвэр бий болгоход зориулах;

д/ Гадаадын байгууллага, пүүсийн төлөөлөгчдийн газраас Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангахад туслахаар үзүүлэх, зуучлах.

е/ Бусад орон, ах дүү хотуудын гадаад эдийн засаг, худалдааны байгууллагуудтай холбоо тогтоох, мэдээлэл, ажилтан солилцох.

ж/ Олон улсын үзэсгэлэн, ярмаг, семинар зөвлөлгөөн зохион байгуулах, явуулахад оролцох.

з/ Гаалийн баталгаат агуулах зохион байгуулах.

#### ГУРАВ. Компанийн эрх

9. Компани нь энэхүү дүрмийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэхийн тулд БНМАУ-ын хууль тогтоомжийн дагуу дараах эрхийг эдлэнэ. Үүнд:

а/ БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр болон хилийн чанадад орших гадаад дотоодын үйлдвэр, аж ахуйн байгууллага, компани, хоршоо, нийгэмлэгтэй харьцаж, тэдэнтэй бүх төрлийн гэрээ, хэлцэл байгуулах, төлбөр тооцоог хийх, харилцан ашигтай байх үндсэн дээр хоршын ажиллах, хамтын үйлдвэрлэл зохион байгуулах, үнэ хаялцах худалдаанд оролцох.

б/ Өөрийн үйл ажиллагаа, ашиг сонирхолтой холбогдсон асуудлаар шүүх, арбитрын байгууллагад нэхэмжлэл гаргах, хариуцагчаар оролцох.

в/ БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр болон хилийн чанадад өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай туслах үйлдвэр, барилга байгууламж

3.

болон хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн чанартай зүйлийг барих, түрээсээр ашиглах, ашиглуулах, худалдах ба худалдан авах.

г/ Шаардлага гарвал БНМАУ-д болон хилийн чанадад өөрийн компанийн салбар, контор, төлөөлөгчийн газрыг тогтсон журмын дагуу байнга буку түр нээн ажиллуулах, татан буулгах.

д/ БНМАУ, бусад улсын банкинд үндэсний болон чөлөөт валютын данстай байх, өөрийн валютын хэрэгслийг зохих журмын дагуу хүүтэйгээр хадгалуулах, түүнийг өөрийн мэдлээр зарцуулж ашиглах.

е/ БНМАУ-ын банкны байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр үндэсний болон чөлөөт валютын зээл авах, өөр байгууллагад урт, богино хугацааны зээл олгох, хувь дэмжигчээр оролцох зэрэг санхүү, валют, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг өрнүүлэн ажиллах.

ж/ Холбогдох байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр тэдгээрийн ажилтнуудыг шаардлагатай үед захиалга, баланс, контрактын төсөл боловсруулах, тохиролцох, контракт байгуулахад татан оролцуулах.

з/ Төрөл бүрийн реклам, сурталчилгааны ажил явуулах, олон улсын хурал зөвлөлгөөн, яармаг, үзэсгэлэн худалдаанд оролцох.

и/ Өөрийн үйл ажиллагаа, зуучлалын үндсэн дээр байгуулагдсан үйлдвэр, аж ахуйн газрын ашиг орлого, хийсэн худалдааны орлого, солилцсон бараа, нийлүүлсэн материал, түүхий эд, тоног төхөөрөмжийн үнийн дүн болон гадаадын байгууллагад зуучилсны орлогын 10 хүртэл хувийг шимтгэлд авч, компанийн ажилг өргөжүүлэх, бусад зарцалд зарцуулах /Шимтгэлийн хувийг тухай бүр тогтоож байна./

к/ Бүтээлч үйл ажиллагааг хөхүүлэн дэмжихийн тулд компанийн ажилтнуудаас болон хамтран ажиллагчийн санаачилгаар оруулсан цэвэр ашгийн 10 хүртэл хувийг урамшуулан шагнахад зориулах.

ДӨРӨВ. Компанийн эд хөрөнгө

10. Компанийн эд хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгөнөөс бүрдэх дүрмийн сан, мөн компанийн үйл ажиллагаа, зуучлалын үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгө, бараа материал, түүхий эд, тоног төхөөрөмж зэрэг гадаад худалдааны үйл ажиллагааны сан/, эдийн засгийн урамшууллын сан болон компанийн мэдэлд өгсөн бусад хөрөнгөөс бүрдэнэ.

Компанийн эд хөрөнгө нь түүний бие даасан тайлан тэнцэлд тусгагдсан байна.

II. Компанийн дүрмийн сан 1500000 төг. болно.

ТАВ. Компанийн бүтэц, удирдлага

12. Компани нь захиргаа, ашиглалтын албаас бүрдэнэ.

13. Компани нь өөрийн болон салбар нэгжийн бүтцийг өөрөө тогтоох ба түүнийг ажлын шаардлагаар боловсронгуй болгон өөрчилж болно.

14. Компанийн үйл ажиллагааг компанийн ерөнхий захирал удирдана.

15. Ерөнхий захирлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа гэрээний үндсэн дээр томилж ба ерөнхий захирал ажлаа түүний өмнө хариуцан тайлагнаж, компанийн үйл ажиллагаа, үр дүнг бүрэн хариуцна.

16. Ерөнхий захирал компанийг төлөөлж дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

а/ Компанийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын бусад байгууллага, иргэнтэй итгэмжлэхгүйгээр шууд харилцаж, төрөл бүрийн гэрээ байгуулж, хэлцэл хийх.

б/ Компанийн эд хөрөнгийг БНМАУ-ын хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах.

в/ Хөдөлмөрийн хууль тогтоомж болон энэхүү гэрээнд заасны дагуу компанийн ажилтан, албан хаагчдыг ажилд авах, ажлаас халах, шагнаж урамшуулах, сахилгын арга хэмжээ авах.

г/ Итгэмжлэл олгох.

д/ Тогтоосон журмын дагуу банкинд харилцах болон бусад данс нээх.

е/ Эрх хэмжээнийхээ дагуу тушаал, заавар гаргах.

ж/ Компанийн ажилтнуудын ажил үүргийн хуваарь, эрх хэмжээг хуваарилан тогтоох.

17. Энэхүү дүрмийн дагуу компаниас хийх гадаад худалдааны аливаа гэрээ хэлцэл 2 гарын үсэгтэй байна. Гэрээ хэлцэлд гарын үсэг зурах эрхийг ерөнхий захирал, мэргэжилтэн болон ерөнхий захирлын гарын үсэг бүхий итгэмжлэхээр эрх олгогдсон бусад этгээд эдэлнэ.

18. Компаниас олгох вексель, төлбөрийн үүргийн бусад баримт ерөнхий захирал, ахлах нягтлан бодогчийн хамт эсвэл ерөнхий

5.

захирлын гарын үсэг бүхий итгэмжлэхээр эрх олгогдсон этгээд, ахлах нягтлан бодогчийн хамт зурсан 2 гарын үсэгтэй байна.

Дурдсан вөксель, талбөрийн үүргийн баримтад ерөнхий захирал, ахлах нягтлан бодогч хоёрын гарын үсэг бүхий итгэмжлэхээр өөр 2 этгээд гарын үсгээ зурж болно.

ЗУРГАА.Тайлан гаргах, ашиг алдагцлаа хуваарилах

19.Компанийн санхүүгийн жилийг жил бүрийн I дүгээр сарын I-нээс 12 дугаар сарын 31-нийг дуустал тогтооно.

20.Компанийн тайлан, тэнцлийг БНМАУ-ын зохих хууль тогтоомжийн дагуу гаргаж батлана.

21.Компани, түүний ажилтнуудын үйл ажиллагаа, зуучлалын үндсэн дээр олсон орлого, ашиг алдагцлыг БНМАУ-ын зохих хууль тогтоомж болон энэхүү дүрмийн дагуу хуваарилна.

22.Компанийн санхүү-аж ахуйн үйл ажиллагааг хянан шалгах ажлыг БНМАУ-ын зохих хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэнэ.

ДОЛОО.Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

23.Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.